

ХАНБОГД СУМЫН МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ханбогд сум

Их булаг

2014 оны 8-р сарын 19-ны өдөр

Та бүхэнд Малчдын төлөөлөгчид болон Оюу Толгой ХХК-н САО-н оролцоотой маргааныг шийдвэрлэх хамтарсан уулзалтаар тохирсон асуудлын талаарх мэдээллээ хүргүүлдэг билээ. Энэ удаад 8-р сарын 19-ны өдөр хийгдсэн уулзалтын талаарх мэдээллийг хүргүүлж байна. Энэхүү уулзалтыг уламжлалт ёсоор Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэний газрын зуучлагч чиглүүлж, Оюу Толгой Хяналт ТТБ малчдын зөвлөхөөр оролцов.

Малчдын төлөөлөл болон компани Жавхлант багийн малчдын гаргасан гомдлын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, шийдвэрлэх тодорхой арга замуудыг эрэлхийлэх талаар хамтарч ажилласнаас хойш нэг жилийн хугацаанд хоёр талаасаа хэрэгжүүлэхээр тохирсон ажлынхаа зорилго, үр дүнг хэлэлцэж, цаашид хэлцлийн үр дүнг хэрхэн сайжруулах талаар санал солилцов.

Уламжлалт ёсоор түрүүчийн уулзалтаас хойш хоёр талаасаа авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар товчхон танилцуулсан бөгөөд Ундай голын голдиролыг өөрчилсөнөөс хойш Ундай голын урсацад хяналт хийж буй тоног төхөөрөмжийг газар дээр нь очиж үзэх, Ундай голын гольдирол өөрчилсөнөөр малчдын бэлчээрийн нөөц, усны хангамж болон усны чанарт нөлөө үзүүлэхгүй байх эсвэл бага нөлөө үзүүлэх өөр хувилбарууд, эсвэл нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээнүүд байгаа эсэх талаар ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн тайланд тусгах Бор Овоогийн задгайн байршлын талаар багийн дарга, малчдын хэлэлцүүлэг зохион байгуулах, ОТ төслөөс 20 км радиуст байгаа худаг нь усгүй болсон малчдыг усаар хангасан зэргийн талаар мэдээлэл солилцов. Компаниас тухайн багийн малчидтай зөвшилцсөний үндсэн дээр энэ оны 6-р сарын 12-оос хоёр сарын түрш Эхэн халив, уурхайн хашааны эргэн тойронд нийт 4 газарт усны ёмкость байрлуулан усаар дүүргэснээр 11 өрхийн тав гаруй мянган мал усалж ирсэн байна. Мөн уурхайн хашаанд түр хугацаанд мал бэлчээрлүүлэх журмын дагуу нэг өрх уурхайн хашаа дотор малаа бэлчээсэн байна. САО-н маргааныг шийдвэрлэх үйл явцын сүүлийн нэг жилийн түрш хоёр талаас хэрэгжүүлэхээр харилцан тохирсон тавь гаруй арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзсэн бөгөөд эдгээрээс түр хугацааны шийдлүүд (ОТ-н хашаанд мал бэлчээрлүүлэх, Худаг нь усгүй болсон ОТ-с 20км доторх өрхүүдэд ус зөөх) болон Ундайн голын гомдлын дагуу ажиллаж байгаа Хөндлөнгийн шинжээчийн багийн ажлын явцыг урагшлуулах өмнө нь тохирсон бөгөөд байгуулаагүй “Нөхөн олговрын ажлын хэсэг”, “Нөхөн сэргээлтийн ажлын хэсэг” байгуулах талаар сумын засаг даргад ОТ компанийн зүгээс хандах зэргийг харилцан тохиролцов. Мөн Оюу Толгой ХХК-ийн Байгаль орчны хэлтсийн усны мэргэжилтэн усны ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны олон төрлийн мониторинг, тэдгээрт малчид хэрхэн оролцож буй, төслийн зүгээс Гүний усны цооногуудыг дурандах үед дахин хоёр цооног шүүрч байгааг олж тогтоосон талаарх мэдээлэл өглөө. Мөн Оюу Толгой ХХК-н материал, нүүрс зэрэг бараа үйлчилгээний тээвэрлэлтийн замын трасс, нөхөн сэргээлтийн талаар компанид малчид дахин санал дэвшүүлсэн байна.

Энэхүү уулзалтын үеэр Бор Овоогийн задгайн байршлын талаар малчдаас гаргасан саналыг танилцуулсан бөгөөд ингэснээр биологийн олон янз байдалд нөлөөлөх мөн задгайн орчимд ургадаг байсан дэрс, цахилдаг гэх мэтийг хэрхэн нөхөх талаар мэргэжлийн дүгнэлт гаргах нь зүйтэй гэж үзлээ. Иймд Оюу Толгой ХХК-н энэ салбарын мэргэжилтэн, орон нутгийн харилцааны ажилтнууд болон малчдын төлөөлөл 8-р сарын 30-аас өмнө уулзаж, зөвлөлдөхөөр болов.

Мөн Ундай голын гольдирол өөрчилсний нөлөөллийн талаар үнэлгээ хийж буй бие даасан шинжээчдийн эхний шатны тайланг эцсийн байдлаар гаргуулж, дүгнэлтүүдийг сонсох нь зүйтэй гэж хоёр тал үзэв. Иймд эдгээр мэргэжилтнүүдийг 8-р сарын сүүлээр Ханбогд суманд ажиллаж нэмэлт мэдээллээ цуглуулж тайлангаа эцэслэн 10-р сарын эхээр танилцуулахыг зөвлөв.

Дараагийн хамтарсан уулзалтыг 9-р сарын сүүлээр хийхээр товлож, сумын Тамгын газраас төлөөлөгчдийн оролцуулахаар болов.

Ханбогд сумын Малчдын төлөөлөгчид,

Оюу Толгой ХХК